



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ШИНЭ-ИДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар A/15

Эрдэнэт

**Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа
иргэний гүйцэтгэх ажлын чиглэл батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн "Журам батлах тухай" 80 дугаар тогтоолын хавсралтын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэнээр гүйцэтгүүлэх ажлын чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Дүйцүүлэх албан хаагчдыг мэргэжлийн удирдлагаар хангаж, үүрэг гүйцэтгэх тухай бүр нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, ажлын үр дүнг тооцон танилцуулж байхыг Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Амгаланбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  М.БАТ-ЭРДЭНЭ



Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын
Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 27-ны
өдрийн А/15 дугаар захирамжийн хавсралт



Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа
иргэдийн гүйцэтгэх ажлын чиглэл

Д/д	Ерөнхий чиглэл	Гүйцэтгэх үүрэг
1	Батлан хамгаалах үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none">- Хууль тогтоомж сурталчлах- Бэлтгэл сургалтад оролцох
2	Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах хор уршгийг арилгах хойшлуулшгүй сэргээн босгох	<ul style="list-style-type: none">- Гамшгийн аюулын зарлан мэдээлэл дамжуулах- Өвс, тэжээл татах, ачих буулгах- Цасанд хаагдсан зам даваа онгойлгох
3	Хүн малын гоц халдварт өвчний үед	<ul style="list-style-type: none">- Хорио цээрийн дэглэм сахиулах, эргүүлээр ажиллах- Зарлан мэдээлэл дамжуулах-
4	Орон нутгийн бүтээн байгуулалтын болон цаг үеийн ажилд оролцох	<ul style="list-style-type: none">- Зам даваа засах- Цэцэрлэгт хүрээлэн тохижуулах- Хагас бүтэн жилийн мал тооллогод оролцох- Нийтээр тэмдэглэх баярын зохион байгуулах ажилд оролцох- Нийгмийн дэг журам сахиулах
5	Байгаль хамгаалах	<ul style="list-style-type: none">- Ой хээрийн түймрийн идэвхтэй үед морин эргүүлээр ажиллах- Байгаль орчны зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах- Мод тарих- Ойн хортон шавж устгах- Булаг, шанд, нуур, голын голдирго цэвэрлэх, хамгаалах
6	Хүн, малын гоц халдварт өвчний үед тогтоосон хорио цээрийн дэглэм сахиулахад дэмжлэг үзүүлэх	<ul style="list-style-type: none">- Зарлан мэдээлэл хүргэх- Хорио цээрийн дэглэм сахиулах эргүүлээр ажиллах- Мал вакцинжуулах ажилд оролцох- Сэг зэмд устгах ажилд оролцож болно.